

**ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ
("Компани")**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

**Халифакс хот, Дартмауф Вайс Роуд, Метрополитан Плэйс, 1480 тоот,
Компанийн оффис
(Атлантын цагаар)
2022 оны 6-р сарын 22-ны өдөр, Лхагва гараг 10 цагт
зохион байгуулагдсан**

ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци ("Компани" эсвэл "Корпораци")-ийн хувьцаа эзэмшигчийн ээлжит хурал эхлэв. Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли өөрийгөө болон Санхүү хариуцсан захирал Роберт Женкинс-ийг танилцуулав.

ХУРЛЫН ДАРГА, НАРИЙН БИЧИГ БА ТООЛЛОГЫН КОМИСС

Петер Акерли нь хурлын даргаар, компанийн хуулийн зөвлөх Жюли Робинсон тэмдэглэл хөтлөх нарийн бичгээр ажиллав. Компьютершэйр Инвестор Сервисэз Инк. ("Computershare") нь тооллогын комиссоор ажилласан.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдэд Компьютершэйр нь 2022 оны 5-р сарын 18-нд хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл хүргүүлсэн. Хурлын дарга хурлын нарийн бичигт энэхүү мэдүүлгийг хурлын тэмдэглэлд хавсаргахыг үүрэг болгов. Мэдүүлгийг Хавсралт "А" хэсэгт хавсаргав.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга нь тооллогын комиссыг биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид эсвэл төлөөлөгчөөр дамжуулан оролцож буй хувьцаа эзэмшигчдийн урьдчилсан тоог гарган, хурлын ирцийн талаар танилцуулахыг үүрэг болгов. Хурлын дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнийг танилцуулав. Хурлын дарга нь энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурал нь хүчин төгөлдөр болохыг танилцуулан, тооллогын комиссыг хурлын ирцийн талаар эцсийн тайланг боловсруулахыг үүрэг болгов. Энэхүү тайланг Хавсралт "В"-д хавсаргав.

ХУРЛЫН ҮЙЛ ЯВЦ

Хурлын дарга нь хурлын хөтөлбөр, үйл явцыг танилцуулав. Хурлын дарга нь хөтөлбөрт дараах долоон асуудлыг хэлэлцэх болохыг тайлбарлав:

- i. 2021 оны 6-р сарын 23-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг хянан баталгаажуулах;
- ii. 2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг танилцуулах;
- iii. Компанийн ирэх жилийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон, томилох;
- iv. Компанийн ирэх жилийн аудиторыг сонгон, томилох, ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олгох;
- v. Опционы урамшууллын хөтөлбөрийн дагуу олгогдвол зохих хуваарилагдаагүй опционыг батлах;
- vi. Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийн дагуу олгогдвол зохих хуваарилагдаагүй ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг батлах;
- vii. Хурлын өмнө гарсан, цаашид зохицуулах шаардлагатай болон бусад асуудал.

Хурлын дарга шийдвэрүүдийг уншиж танилцуулах ба санал оруулж, саналыг дэмжих эсэхийг асууна. Санал хураалт хийгдэнэ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын дарга нь 2021 оны 6-р сарын 23-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлтэй хувьцаа эзэмшигчид өөрийн хүсэлтээр танилцах боломжтойг тэмдэглэв.

Санал хураалтаар 2021 оны 6-р сарын 23-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлтэй хувьцаа эзэмшигчид танилцсан гэдгийг баталгаажуулав.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хурлын дарга нь 2021 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулга болон аудиторын тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн хурлын дарга нь санхүүгийн тайлан нь SEDAR-т тайлагнан, хувьцаа эзэмшигчдэд хүргүүлснийг дурдав. ТУЗ-ийн дарга KPMG LLP-ийн аудитын дүгнэлт нь цэвэр ба зөрчилгүй гарсныг тэмдэглэв. Санхүүгийн тайлан болон аудиторын тайлантай холбоотой асуулт байхгүй байв.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОН, ТОМИЛОХ

Хурлын дарга нь дараагийн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийг сонгон, томилох талаар танилцууллаа. Хурлын дарга нь ирэх жилд ТУЗ нь найман (8) гишүүнээс бүрдэн үйл ажиллагаа явуулахыг онцлов. Хурлын эцэст ТУЗ нь найман (8) гишүүнээс бүрдэх болов.

Дараах найман нэр дэвшигч ТУЗ-д нэр дэвшиж байгааг хурлын дарга танилцуулав:

Др. Анна Биолик
Жон Бюрн
Лэйтон Крофт
Кеннет МакДоналд

Камерон МакРэй
Дэвид Мошер
Хэдли Виддап болон
Петер Акерли

Хурлын дарга нь Компанийн дүрмийн дагуу хурлын үеэр нэмж ТУЗ-д нэр дэвших гишүүнийг хүлээн зөвшөөрөхгүйг танилцуулав.

Нэр дэвшүүлж, санал хурааснаар Др. Анна Биолик, Жон Бюрн, Лэйтон Крофт, Кэннет МакДоналд, Камерон МакРэй, Дэвид Мошер, Хэдли Виддап болон Петер Акерли нарыг компанийн ТУЗ-ийн гишүүдээр томилж, дараагийн гишүүд томилогдох хүртэл ТУЗ-ийн гишүүдийн ажлыг гүйцэтгэхээр томилов.

АУДИТОРЫГ ТОМИЛОХ

Хэлэлцүүлэх дараагийн асуудалд дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал, эсвэл дараагийн компани томилогдох хүртэл Компанийн аудитораар ажиллах байгууллагыг сонгон томилох, ТУЗ-д аудиторын хөлс, урамшууллыг тогтоох эрхийг олгох асуудлыг хэлэлцсэн.

Нэр дэвшүүлж, санал хурааснаар мэргэшсэн нягтлан бодогчид Кэй Пи Эм Жи ХХН (“KPMG LLP”)-г хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эсвэл дараагийн аудитор томилогдох хүртэл компанийн аудитораар томилж, ТУЗ-д аудиторын хөлс, урамшууллыг тогтоох эрхийг олгохоор тогтов.

ХУВААРИЛАГДААГҮЙ ОПЦИОНЫГ БАТЛАХ

Хурлын дарга нь хэлэлцүүлэх дараагийн асуудалд компанийн хувьцааны опционы төлөвлөгөөний дагуу олгогдвол зохих хуваарилагдаагүй опционыг батлах асуудал байгааг тэмдэглэв. Хурлын дарга нь Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын дагуу Компанийн хувьцааны опционы төлөвлөгөөний дагуу олгогдвол зохих хуваарилагдаагүй опционыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар гурван жил тутамд баталгаажуулах үүрэгтэйг танилцуулсан. Мөн тэрээр 2019 оны 6-р сарын 20-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хуваарилагдаагүй опционыг баталгаажуулж байсныг танилцуулсан.

Хурлын дарга нь энэхүү асуудлын хурлын тогтоолын төсөл нь Удирдлагын мэдээллийн танилцуулгын 15 болон 16-р хуудсанд тусгагдсан байгааг тэмдэглэж, энэхүү тогтоолыг батлах талаар санал авлаа. Санал хураалтаар тогтоолыг батлав.

Хурлын дарга нь саналын хуудсаар санал хураалтыг явуулсныг танилцуулсан ба тооллогын комисс бүх саналын хуудсыг хүлээн авсныг баталгаажуулав. Мөн хурлын дарга нь Компьютершэйр-ийн төлөөлөгчийг саналын хуудасны тайланг уншихыг урьдсан бөгөөд энэхүү тэмдэглэлийн Хавсралт “С”-д хавсаргав. Хурлын дарга нь Компьютершэйр-ийн тайланг баталгаажуулж, Удирдлагын мэдээллийн танилцуулгын 15 болон 16-р хуудсанд буй хуваарилаагүй опционы тухай хурлын тогтоолыг баталсныг мэдэгдэв.

ХУВААРИЛАГДААГҮЙ ИРЭЭДҮЙД ОЛГОГДОХ ХУВЬЦААНЫ ЭРХИЙГ БАТЛАХ

Хурлын дарга нь хэлэлцүүлэх дараагийн асуудалд Компанийн хувьцааны ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн ("ИОХЭ") хөтөлбөрийн дагуу олгогдвол зохих хуваарилагдаагүй ИОХЭ-г батлах асуудал байгааг тэмдэглэв. Мөн 2019 оны 6-р сарын 20-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчид ИОХЭ-ийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахыг танилцуулж баталсан тухайг тэмдэглэв. Хурлын дарга нь Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын дагуу компанийн хувьцааны ИОХЭ-н хөтөлбөрийн дагуу олгогдвол зохих хуваарилагдаагүй ИОХЭ-г хувьцаа эзэмшигчдийн хурлаар гурван жил тутамд баталгаажуулах үүрэгтэйг танилцуулсан.

Хурлын дарга нь Удирдлагын мэдээллийн танилцуулгын хуудас 17-д тусгасан тогтоолын төслийг танилцуулж, санал хураасан. Хувьцаа эзэмшигчид санал өгч, зөвшөөрөв.

Хурлын дарга нь саналын хуудсаар санал хураалтыг явуулсныг танилцуулсан ба тооллогын комисс бүх саналын хуудсыг хүлээн авсныг баталгаажуулав. Хурлын дарга нь саналын хуудасны тайланг Компьютершэйр-ээс хүлээн авч, энэхүү тэмдэглэлийн Хавсралт "D"-д хавсаргасныг мэдэгдэв. Хурлын дарга нь Компьютершэйр-ийн тайланг баталгаажуулж, Удирдлагын мэдээллийн танилцуулгын 17-р хуудсанд буй хуваарилаагүй ИОХЭ-н тухай хурлын тогтоолыг баталсныг мэдэгдэв.

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга хэлэлцэх нэмэлт асуудал байгаа эсэхийг тодруулав.

Хэлэлцэх нэмэлт асуудал байхгүй байсан тул хурлыг эцэслэх санал гарган зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөв.

Жюли Робинсон, тэмдэглэл хөтөлсөн нарийн бичиг

Хавсралт "А"

Компьютершэйр Инвестор Сервисез Инк. Шуудангаар хүргүүлсэн мэдүүлэг

Хавсралтаас танилцана уу.

Хавсралт "В"

Тооллогын комиссын тайлан

Хавсралтаас танилцана уу.

Хавсралт "С"

**Хуваарилагдаагүй опционыг батлах тооллогын комиссын гаргасан саналын
хуудасны тайлан**

Хавсралтаас танилцана уу.

Хавсралт "D"

**Хувилагаагүй ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг батлах тооллогын
комиссын гаргасан саналын хуудасны тайлан**

Хавсралтаас танилцана уу.